



МОНГОЛЫН  
ИТГЭМЖЛЭЛИЙН  
ТОГТОЛЦОО

БАТЛАВ.  
ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН  
ТӨВИЙН ДАРГА

.....С.НЯМ-ЭРДЭНЭ

## ИТГЭМЖЛЭЛИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ, ТАНИХ ТЭМДЭГ, ТЭМДЭГ БА ГЭРЧИЛГЭЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Боловсруулсан:	Хянаж, өөрчлөлт оруулсан:
Ахлах мэргэжилтэн	Чанарын менежер
З.Мөнхбат	Д.Удвал

Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр, В корпус,  
Улаанбаатар 15160, Монгол Улс  
Утас: (976) 77073689

Цахим хуудас: [www.mnas.gov.mn](http://www.mnas.gov.mn)  
Цахим шуудан: [info@mnas.gov.mn](mailto:info@mnas.gov.mn)

**ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.**

## АГУУЛГА

№	Бүлгийн нэр	Хуудас
1	Зорилго .....	3
2	Хамрах хүрээ .....	3
3	Ашигласан баримт бичгүүд.....	3
4	Нэр томъёо, тодорхойлолт .....	3
5	Итгэмжлэлийн байгууллагын бэлгэ тэмдэг .....	4
6	Итгэмжлэгдсэнийг таних тэмдэг .....	4
7	Итгэмжлэлийн байгууллагын тэмдэг(Дардас).....	5
8	Итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдэг бүхий тайлан, гэрчилгээг гаргах .....	5
9	Итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдэг бүхий шалгалт тохируулгын гэрчилгээ, шошго олгох .....	5
10	Сурталчилгаа, хэвлэл дээр итгэмжлэлийн таних тэмдгийг хэрэглэх .....	6
11	Итгэмжлэлийн байгууллагын бэлгэ тэмдэг, итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдэг, итгэмжлэлийн эрх зүйн байдлыг буруугаар хэрэглэхийг зохицуулах .....	6
	ХАВСРАЛТ 1 .....	8
	ХАВСРАЛТ 2 .....	9
	Өөрчлөлтийн бүртгэл	10

<b>ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ</b>		
Баримт бичгийн No: MNAS P704	Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээ хэрэглэх журам	
Хэвлэсэн огноо: 12.10.2011	Өөрчлөлт No: 06	Page 2 of 10
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

# ИТГЭМЖЛЭЛИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ, ТАНИХ ТЭМДЭГ, ТЭМДЭГ БА ГЭРЧИЛГЭЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

## MNAS P704

### 1 ЗОРИЛГО

Энэхүү журам нь итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээг зөв хэрэглэх, итгэмжлэлийн байгууллагын нэр хүндийг хамгаалах зорилготой.

### 2 ХАМРАХ ХҮРЭЭ

Итгэмжлэлийн байгууллагын бэлгэ тэмдэг, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын таних тэмдэг, тэмдэг, итгэмжлэлийн гэрчилгээ болон түүний хавсралтыг ашиглах, хянах явцыг зохицуулна.

### 3 АШИГЛАСАН БАРИМТ БИЧГҮҮД

Энэхүү журамд дараахь баримт бичгүүдийг ашигласан. Үүнд:

- *MNS ISO/IEC 17011, Тохирлын үнэлгээ – Тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжлэх итгэмжлэлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага;*
- *ILAC P8:11/2023 Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (Хэлэлцээр): Итгэмжлэлийн таних тэмдэг ашиглах, тохирлын үнэлгээний байгууллагаас итгэмжлэгдсэн байдлаа илэрхийлэхэд тавих нэмэлт шаардлага*

### 4 НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ

#### 4.1

#### **итгэмжлэлийн байгууллагын бэлгэ тэмдэг (лого)**

итгэмжлэлийн байгууллагын эрх зүйн байдлыг илэрхийлэхийн тулд хэрэглэх бэлгэ тэмдэг

#### 4.2

#### **итгэмжлэлийн таних тэмдэг**

итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн эрх зүйн байдлыг нь илэрхийлэхийн тулд хэрэглэх, итгэмжлэлийн байгууллагаас олгосон таних тэмдэг

#### 4.3

#### **итгэмжлэлийн тэмдэг**

итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага итгэмжлэлийн хүрээнд хийгдсэн сорилт, шалгалт тохируулга, баталгаажуулалт, хяналтын ажлын үр дүнг баталгаажуулахаар хэрэглэх итгэмжлэлийн байгууллагаас олгосон дардас

#### 4.4

#### **эрх бүхий гарын үсэг зурагч**

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P704	Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээ хэрэглэх журам	
Хэвлэсэн огноо: 12.10.2011	Өөрчлөлт No: 06	Page 3 of 10
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

итгэмжлэгдсэнийг таних тэмдэг (4.2) бүхий гэрчилгээ, тайлан дээр гарын үсэг зурахаар томилогдсон ажилтан

#### 4.5

##### итгэмжлэлийн гэрчилгээ

тохирлын үнэлгээний байгууллага итгэмжлэгдсэн болохыг баталж итгэмжлэлийн байгууллагаас олгох гэрчилгээ, тушаал, хавсралтын хамт

#### 4.6

##### бүртгэлийн дугаар

итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагад өгөх код.

### 5 ИТГЭМЖЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БЭЛГЭ ТЭМДЭГ

**5.1** Итгэмжлэлийн байгууллагын бэлгэ тэмдэг нь 1-р хавсралтад үзүүлсэн загвартай байна. Бэлгэ тэмдгийн дэвсгэр өнгө нь хөх (С 100%, М 060%, Y 000%, К 000%), соёмбоны өнгө нь шар (С 000%, М 015%, Y 100%, К 000%) болон MNAS, Accreditation system гэсэн үгнүүд цагаан өнгөтэй байна. Бэлгэ тэмдгийг загварын дагуу томруулах буюу багасган хэрэглэж болох ба 2:1.5-ийн харьцаатай байна.

**5.2** Итгэмжлэлийн байгууллага нь өөрийн бэлгэ тэмдгийг хэвлэл мэдээлэл, гэрчилгээ, баримт бичиг, албан бичиг, сурталчилгаа, электрон баримт бичиг, вэбсайт дээр хэрэглэж болно.

### 6 ИТГЭМЖЛЭГДСЭНИЙГ ТАНИХ ТЭМДЭГ

**6.1** Итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн ТҮБ-д олгогдох таних тэмдэг нь итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, бүртгэлийн дугаар, холбогдох стандартын тэмдэглэгээнээс бүрдэнэ. Таних тэмдгийг 2-р хавсралтад заасан загварын дагуу томруулах буюу багасгаж хэрэглэж болох ба 2.4:1.5 харьцаатай байна.

**6.2** Итгэмжлэгдсэн ТҮБ-ын бүртгэлийн дугаар нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

- a) TLxxx үсгээр итгэмжлэгдсэн сорилтын лаборатори;
- b) CLxxx үсгээр итгэмжлэгдсэн шалгалт тохируулгын лаборатори;
- c) PCxxx үсгээр итгэмжлэгдсэн бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллага;
- d) MSCxxx үсгээр итгэмжлэгдсэн тогтолцооны баталгаажуулалтын байгууллага;
- e) IBxxx үсгээр итгэмжлэгдсэн хяналтын байгууллага;
- f) MLxxx үсгээр итгэмжлэгдсэн эмнэлгийн лаборатори;
- g) PTRxxx үсгээр итгэмжлэгдсэн ур чадварын сорилт зохион байгуулагч лаборатори;
- h) AVxxx үсгээр итгэмжлэгдсэн ажилтны баталгаажуулалтын байгууллага

**6.3** Итгэмжлэлийн таних тэмдгийн эзэмшигч нь итгэмжлэлийн байгууллага байх ба итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага түүнийг зөвхөн итгэмжлэгдсэн үйл ажиллагааны хүрээнд, хүчинтэй хугацаанд хэрэглэх эрхтэй.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS P704	Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээ хэрэглэх журам	
Хэвлэсэн огноо: 12.10.2011	Өөрчлөлт No: 06	Page 4 of 10
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

**6.4** Итгэмжлэлийн таних тэмдгийг итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага нь өөрийн үр дүн, дотоод баримт бичиг, сурталчилгааны материал, электрон баримт бичиг, вэбсайт дээр хэрэглэж болно.

**6.5** Итгэмжлэлийг түдгэлзүүлсэн, цуцалсан, гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд итгэмжлэлийн таних тэмдэг хэрэглэхийг хориглоно.

## **7 ИТГЭМЖЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТЭМДЭГ (ДАРДАС)**

**7.1** Итгэмжлэлийн хүрээнд хийсэн сорилт, шалгалт тохируулга, баталгаажуулалт, хяналтын үр дүнг баталгаажуулах зорилгоор итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагад тэмдэг эзэмшүүлнэ.

**7.2** Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага тэмдгийг итгэмжлэлийн таних тэмдэг бүхий үр дүнгийн хуудсан дээр хэрэглэнэ.

**7.3** Итгэмжлэлийн тэмдэг дээр “Итгэмжлэгдсэн сорилт/шалгалт тохируулгын лаборатори, баталгаажуулалт/хяналтын байгууллага” гэсэн бичиг, бүртгэлийн дугаар байна.

## **8 ИТГЭМЖЛЭЛИЙН ТАНИХ ТЭМДЭГ, ТЭМДЭГ БҮХИЙ ТАЙЛАН, ГЭРЧИЛГЭЭГ ГАРГАХ**

**8.1** Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага нь зөвхөн итгэмжлэлээр тогтоосон хүрээнд хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд итгэмжлэлийн таних тэмдэг бүхий гэрчилгээ, тайлан хэвлэж, тэмдгээр баталгаажуулна.

**8.2** Итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдгийг ашиглан электрон буюу цаасан хэлбэрээр тайлан гаргах, гэрчилгээний загварыг итгэмжлэлийн байгууллагатай тохиролцсоны дагуу батлах бөгөөд агуулга нь холбогдох стандартын шаардлагад нийцсэн байна.

**8.3** Итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдэг бүхий гэрчилгээ, тайланг итгэмжлэлийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн эрх бүхий ажилтан баталгаажуулсан байна.

**8.4** Тайлан, гэрчилгээнд илэрхийлсэн үр дүн нь итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод ороогүй тохиолдолд итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдэг хэрэглэхгүй. Хэрэв тайлан, гэрчилгээнд итгэмжлэгдээгүй хүрээг оруулах бол энэ тухай тэмдэглэсэн байна.

## **9 ИТГЭМЖЛЭЛИЙН ТАНИХ ТЭМДЭГ, ТЭМДЭГ БҮХИЙ ШАЛГАЛТ ТОХИРУУЛГЫН ГЭРЧИЛГЭЭ, ШОШГО ОЛГОХ**

**9.1** Итгэмжлэгдсэн шалгалт тохируулгын лабораторийн гаргаж байгаа гэрчилгээнд шалгалт тохируулгын үр дүнтэй холбоотой хэмжлийн тодорхой бус байдлыг зохих ёсоор тооцож оруулсан байна.

**9.2** Итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдэг бүхий шалгалт тохируулга хийсэн хэмжих хэрэгслийн шошгонд дараахь мэдээлэлийг оруулна. Үүнд:

<b>ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ</b>		
Баримт бичгийн No: MNAS P704	Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээ хэрэглэх журам	
Хэвлэсэн огноо: 12.10.2011	Өөрчлөлт No: 06	Page 5 of 10
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

- a) итгэмжлэлийн байгууллагын таних тэмдэг;
- b) итгэмжлэгдсэн шалгалт тохируулгын лабораторийн нэр, итгэмжлэлийн гэрчилгээний бүртгэлийн дугаар;
- c) багажийн тодорхойлолт;
- d) шалгалт тохируулга хийсэн огноо;
- e) шалгалт тохируулгын гэрчилгээний эш таталт.

## **10 СУРТАЛЧИЛГАА, ХЭВЛЭЛ ДЭЭР ИТГЭМЖЛЭЛИЙН ТАНИХ ТЭМДГИЙГ ХЭРЭГЛЭХ**

**10.1** Итгэмжлэгдсэн ТҮБ дараахь материалууд дээр итгэмжлэлийн таних тэмдгийг хэрэглэж болно.

- a) хэвлэл, сурталчилгааны материал;
- b) танилцуулга, байгууллагын хэвлэл;
- c) техникийн өгүүлэл;
- d) ажлын тайлан г.м.

**10.2** Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн тухай мэдэгдэл нь зөвхөн итгэмжлэлийн хүрээгээр тогтоосон сорилт, шалгалт тохируулга, баталгаажуулалт, хяналтын ажилд хамааралтай.

**10.3** Итгэмжлэлийн таних тэмдэг нь бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагаа болон үйлчилгээ (түүний аль нэг хэсэг) нь MNAS-аар баталгаажсан болон батлагдсан гэдгийг илэрхийлэхгүй.

## **11 ИТГЭМЖЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БЭЛГЭ ТЭМДЭГ, ИТГЭМЖЛЭЛИЙН ТАНИХ ТЭМДЭГ, ТЭМДЭГ, ИТГЭМЖЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ БУРУУГААР ХЭРЭГЛЭХИЙГ ЗОХИЦУУЛАХ**

**11.1** Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдэг болон эрх зүйн байдлыг буруугаар ашигласан тохиолдолд итгэмжлэлийг түдгэлзүүлэх, цуцлах зэрэг арга хэмжээ авна.

**11.2** Итгэмжлэгдээгүй тохирлын үнэлгээний байгууллага итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдэг хэрэглэхгүй ба хэрэв ашигласан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**11.3** Тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийг түдгэлзүүлсэн, цуцалсан тохиолдолд итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдэг ба мэдэгдлийг хэрэглэхээ зогсооно.

<b>ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ</b>		
Баримт бичгийн No: MNAS P704	Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээ хэрэглэх журам	
Хэвлэсэн огноо: 12.10.2011	Өөрчлөлт No: 06	Page 6 of 10
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

**11.4** Итгэмжлэлийн байгууллагын зөвшөөрсөн гарын үсэг зурагч эзгүй байх тохиолдолд түүнийг орлох хүнийг томилох ба эсвэл шинээр гарын үсэг зурагч томилохоор итгэмжлэлийн байгууллагад хандаж болно.

**11.5** Итгэмжлэлийн байгууллага итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагад магадлах шалгалт, давтан үнэлгээ, санал гомдлын мөрөөр үзлэг хийхдээ итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдгийн ашиглалтад хяналт тавина. Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага итгэмжлэлийн гэрчилгээ, түүний хавсралтыг буруугаар ашиглах, итгэмжлэгдсэн эрх зүйн байдлын талаар хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулах байдлаар илэрхийлсэн бол анхааруулах, итгэмжлэлийг түдгэлзүүлэх, цуцлах зэрэг арга хэмжээг авна.

---xxx---

<b>ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ</b>		
Баримт бичгийн No: MNAS P704	Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээ хэрэглэх журам	
Хэвлэсэн огноо: 12.10.2011	Өөрчлөлт No: 06	Page 7 of 10
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

## ХАВСРАЛТ 1

Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг (лого)-ийн загвар



<b>ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ</b>	
Баримт бичгийн No: MNAS P704	Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээ хэрэглэх журам
Хэвлэсэн огноо: 12.10.2011	Өөрчлөлт No: 06
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.	

Page 8 of 10

## ХАВСРАЛТ 2

### Итгэмжлэлийн таних тэмдгийн загвар

#### Сорилт



#### Шалгалт тохируулга



#### Бүтээгдэхүүний баталгаажуулалт



#### Тогтолцооны баталгаажуулалт




#### Хяналт



#### Эмнэлгийн лаборатори



#### Ур чадварын сорилт



#### ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

Баримт бичгийн No: MNAS P704	Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээ хэрэглэх журам	
Хэвлэсэн огноо: 12.10.2011	Өөрчлөлт No: 06	Page 9 of 10
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.

## ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлт No	Хуудасны №	Өөрчлөлтийн шалтгаан
1	01	Бүгд	Хуудасны форматыг шинэчилсэн.
2	02	5	б.3-д, а) ML- итгэмжлэгдсэн эмнэлгийн лабораторийг заана, б) РТР- итгэмжлэгдсэн ур чөдвөрын сорилт зохион байгуулагчийг заана... гэж нэмсэн.
3	03	1	MNAS шинэ хуулийн этгээд болсон тул уг баримт бичгийг MNAS-аар баталгаажуулсан. Энэ шалтгаанаар хянагдсан болон баталсан хүмүүсийн нэрс өөрчлөгдсөн.
4	04	9	2-р хавсралтад...загварын магадлан итгэмжлэлийн тэмдгийг... нэмсэн.
5	05	Бүгд	Бүхэлд нь хянасан.
6	06	Бүгд	ILAC P8:11/2023 баримт бичиг шинэчлэгдсэн тул хянасан.

### ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

Баримт бичгийн No: MNAS P704	Итгэмжлэлийн бэлгэ тэмдэг, таних тэмдэг, тэмдэг ба гэрчилгээ хэрэглэх журам	
Хэвлэсэн огноо: 12.10.2011	Өөрчлөлт No: 06	Page 10 of 10
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		